



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)¹

НӨАТ-ЫН ИЛҮҮ ТӨЛӨЛТ БУЦААН АВАХ ХҮСЭЛТЭД ҮНДЭСЛЭЖ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ТОХИОЛДОЛД ТАТВАРЫН АЛБА САНХҮҮГИЙН БОЛОН БУСАД БАРИМТЫГ ТАТВАР ТӨЛӨГЧӨӨС ШААРДАХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2024/0085

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 09 сарын 23 өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын хяналтын журмаар гаргасан гомдлыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч хуулийн этгээд нь 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр “нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийг буцаан авах тухай” хүсэлт гаргасны дагуу хариуцагч татварын улсын байцаагч нар хяналт шалгалтын ажиллагааг явуулж, нэхэмжлэгчээс холбогдох санхүүгийн болон бусад баримтыг шаардсан байна. Харин нэхэмжлэгч хуулийн этгээдээс “Өмнө шалгаж нөхөн ногдуулалтын акт үйлдсэн, маргаан таслах зөвлөл болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр хянан шийдвэрлэсэн баримтууд тул дахин гаргаж өгөх үндэслэлгүй” гэж үзэж гаргаж өгөхөөс татгалзсан байна.

Хариуцагч татварын улсын байцаагч нар дээрх татгалзлыг Татварын ерөнхий хууль (2019)-ийн 41 дүгээр зүйлийн 41.12.3² дахь заалтад заасан үүргээ зөрчсөн гэж үзэж нэхэмжлэгчид Зөрчлийн тухай хууль (2019)-ийн 11 дүгээр зүйлийн 11.19 дүгээр зүйлийн 7.3³ дахь заалтад заасан үндэслэлээр дөрвөн мянган нэгжээр торгох шийтгэл оногдуулжээ.

Иймд нэхэмжлэгчээс шаардсан баримт нь татварын хяналт шалгалтад шаардлагатай баримт биш гэж, хариуцагч нараас “... шаардсан баримтыг гаргаж өгөөгүй, шийтгэлийн хуудас хуульд нийцсэн” хэмээн тус тус маргасан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3278?daterange=2024/01/01%20-%202024/10/30%20&id=3&court_cat=3&bb=1

² Татварын ерөнхий хууль (2019)-ийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсэг “Татвар төлөгч нь татварын хяналт шалгалтад дараах эрх, үүрэгтэй байна.”, 41.12.3 дахь заалт “татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгч, татварын хяналт шалгалтад хамрагдах”.

³ Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 11.19 дүгээр зүйлийн 7.3 дахь заалт “татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй”.



- 1. Анхан шатны шүүхээс:** “... “хариуцагч нараас шаардсан баримтуудыг гаргаж өгөхөөс татгалзсан нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд хамаарна” гэх үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 7.3 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12.3 дахь заалтад заасныг тус тус баримтлан гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
- 2. Давж заалдах шатны шүүхээс:** “... “татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй” зөрчил гаргасан нь тогтоогдсон” гэх үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.
- 3. Нэхэмжлэгч хуулийн этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зүгээс:** “... өмнө шалгалт хийгдэж тогтоогдсон хугацааны баримтууд нь Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12.3 дахь заалтад заасан шаардлагатай санхүүгийн баримт биш, татварын улсын байцаагч нар нэмэгдсэн өртгийн албан татварын хяналт шалгалтаас хэтэрч, иж бүрэн шалгалт шиг баримт шаардаж байна, шүүхүүд энэ байдлыг зөвтгөж, “татварын улсын байцаагч нарын шаардсан баримтууд нь зайлшгүй шаардлагатай” гэж үзэж байгаад гомдолтой” гэх үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргасан.
- 4. Хяналтын шатны шүүхээс:** Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэгт “татварын алба эрсдэлд, эсхүл татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн татвар төлөгчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгана” гэж зааснаар татварын хяналт шалгалтыг татварын алба эрсдэлд үндэслэн өөрийн, эсхүл хүсэлтээр буюу татвар төлөгчийн санаачилгаар хэрэгжүүлэхээр байна. (16)⁴
- 5.** Татварын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дахь заалтад татвар төлөгч “илүү төлсөн татварыг буцаан авах, суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах” эрхтэй байхаар хуульчилсан бөгөөд нэхэмжлэгч нь тухайн эрхийн хүрээнд “нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийг буцаан авах тухай” хүсэлтээ гаргажээ. (17)
- 6.** Татвар төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийг буцаан авах хүсэлтэд үндэслэн тухайн татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх тохиолдолд татварын улсын байцаагч холбогдох баримтыг шаардаж болох боловч шаардсан баримтыг гаргаж өгөөгүй нь татвар төлөгчийг татварын хууль тогтоомжийг зөрчсөн буюу Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12.3 дахь заалтад заасан үүргээ биелүүлээгүй гэх үндэслэл болохгүй. Өөрөөр хэлбэл, татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгөх үүргийг татварын албаны санаачилгаар явагдаж байгаа хяналт шалгалтын үед татвар төлөгчөөс шаардахаас бус эрхийнхээ хүрээнд гаргасан хүсэлтэд үндэслэсэн хяналт шалгалтын үед шаардахгүй. (18)
- 7.** Тодруулбал, хариуцагч Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэгт Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны

⁴ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



байгууллагаас хянаж, буцаан олгох татварын хэмжээг тодорхойлж баталгаажуулснаар Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас буцаан олгох шийдвэр гаргахаар хуульчилсны дагуу нэхэмжлэгчийн хүсэлт, гаргаж өгсөн баримтын хүрээнд 2012-2016 оноос бусад хугацааны буцаан олгох албан татварын хэмжээг хянаж, баталгаажуулах эсэхийг шийдвэрлэх боломжтой. (19)

8. Дээрх үндэслэлээр хяналтын шатны шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, гомдол гаргагчийн шийтгэлийн хуудас хүчингүй болгуулах гомдлын шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.